

БАТЛАВ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д. ГАНХУЯГ

2022 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	ЗОРИЛГО	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХҮРЭХ ҮР ДҮН
1.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	1.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал. 1.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцож, гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх зохион байгуулж ажилласан байна.
2.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	2.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх.	Авлигаас урьдчилан сэргийлэх, авлига гарах боломжийг бууруулах талаар арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна.

3.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.	3.1.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасныг хэрэгжүүлэх.	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.
		3.2.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасныг хэрэгжүүлэх.		
		3.3.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах.		
4.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг дээшлүүлэх.	4.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фейсбүүк, твиттер, youtube суваг/ мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л бололцоотой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх.	Холбогдох мэдээллийг баримтжуулж, цахим болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн байх.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, сурталчилгааны баннер, богино хэмжээний видео контентуудыг яамны цахим хуудсанд байршуулж, мэдээлэл, сурталчилгааны зураг, бусад материалыг Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд 3-аас доошгүй удаа хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.
		4.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, нэгж, харьяа байгууллагын онцлогт тохируулж зохион байгуулах.	Дэмжиж хамтран ажилласан байх.  Байгууллага, түүний нэгж, харьяа байгууллагад аян, арга хэмжээг зохион байгуулж ажиллах.	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй мэдээлэл солилцож, авлигын эсрэг аян, арга хэмжээг 2-оос доошгүй удаа хэрэгжүүлж ажилласан байна.

		4.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлж сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх.  Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” тусгай дугаар бүхий баннерыг яамны цахим хуудасны Ил тод цэсэд шинэчлэн байршуулж, холбогдох мэдээллийг тухай бүрт нь цаг алдалгүй тусгаж, зохион байгуулж ажилласан байна.
5.	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах.	5.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх.	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх.	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын эсрэг сургалтын санал, захиалгад тухай бүр алба хаагчдын нэрсийг хүргүүлж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан байна.
		5.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад алба хаагчдаа хамруулсан байх.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо гарсан байх.	Анхан шатны сургалтад 5-аас доошгүй, давтан сургалтад 5-аас доошгүй алба хаагчийг хамруулсан байна.
		5.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх.	Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх.  Хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо гарсан байх.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг харьяа байгууллага, иргэд, олон нийтэд 2-оос доошгүй удаа хүргэж ажилласан байна.
6.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх,	6.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж.	Зөвлөмж, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байх.	Авлигатай тэмцэх газар, мөрдөгчөөс ирүүлсэн зөвлөмж, мэдэгдлийг хэрэгжүүлж, үүссэн зөрчлийг арилгасан байна.
		6.2.Мөрдөгчийн мэдэгдэл.		
		6.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ.		

	хариуг хугацаанд нь мэдэгдэх.			
7.	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсны үндсэн зохих албан тушаалд томилох, хэрэгжилтийг зохион байгуулах.	<p>7.1.Нийтийн албанд томилогдох алба хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр АТГ-т хянуулах.</p> <p>7.2.Нийтийн албанд шинээр болон сэлгэн томилогдсон алба хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн дагуу гаргуулан авах.</p> <p>7.3.Алба хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн дагуу жил бүр шинэчлэн гаргуулан авах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, АТГ-т ХАСХОМ-ийг тайлант хугацаанд нэгтгэн хүргүүлэх.</p>	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Алба хаагчдын ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж дүгнэлт гаргуулсан, хуульд заасны дагуу алба хаагчдын ХАСХОМ-ийн мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, мэдүүлгийг АТГ-т хүргүүлсэн байна.
8.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх.	<p>8.1.Батлан хамгаалах яамны иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, зөвлөгөө, мэдээлэл өгөх алба хаагчийг ажиллуулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих.</p> <p>8.2.Авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг авах тусгай дугаарыг тогтмол ажиллуулах.</p>	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, зөвлөгөө, мэдээлэл өгөх, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах тусгай дугаарын утсыг ажиллуулсан байна.

9.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	9.1.Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагын цахим хуудастай танилцаж, тухайн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх.	Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нууцад хамаарахаас бусад асуудлын ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах.	Нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж, байгууллагынхаа цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээг тогтмол тусгаж ажиллах.
		9.2.Байгууллагын үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд хүргэх. /бичмэл тайлан, инфографик/		

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:


ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН



Л.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:


ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
ЯАМНЫ ХУУЛИЙН ЗӨВЛӨХ



Г.ЭНХБОЛД

ТАНИЛЦСАН:

СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА ХУРАНДАА



Ч.ГАНДИРВАА